

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 03 дугаар
сарын 08 өдөр

Дугаар А/138, А/37

Улаанбаатар
хот

Журам, шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газар /П.Оюунцэцэг/, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Билэгдэмбэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар /С.Сүнчин/-т, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Салбарын хяналтын газар /С.Ганзориг/-т тус тус даалгасугай.

Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийн талаар мөрдөх журам батлах тухай” 140 дүгээр, “Эрүүл мэндийн чиглэлийн төрөлжсөн программ хангамжийг эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх журам батлах тухай” 193 дугаар, 2022 оны “Мэдээллийн технологийн зөвлөл байгуулах тухай” А/52 дугаар, “Эрүүл мэндийн мэдээллийн технологийн техникийн хороо шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” А/54 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.





Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа
 холбооны сайдын хамтарсан 2024 оны 09 сарын 26
 өдрийн 1.1/1.1/1 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ашиглагдах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж нь дараах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

№	Бүлэг	№	Шаардлага	Зайлшгүй шаардлагатай	Зөвлөмжийн шинжтэй
Нэг. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА					
Энэхүү ерөнхий шаардлага дахь "Зайлшгүй шаардлагатай" байх шалгуур үзүүлэлтийг заавал шаардах ба "Зөвлөмжийн шинжтэй" байх шалгуур үзүүлэлтийг заавал хөгжүүлж, нэвтрүүлэхгүй байж болно.					
1.1.	Технологи	1.	Программ хангамж, түүний бүрэлдэхүүн нь оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй байх	+	
		2.	Өгөгдлийн сангийн программ хангамж нь оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй байх	+	
		3.	Олон төрлийн үйлдлийн систем дэмждэг байх (WINDOWS, UNIX гэх мэт)		+
		4.	Хандалтын тооноос хамаарч ачаалал даах чадвартай байх (Stress test result)	+	
		5.	Аудит бүртгэл (audit log)-ийг үүсгэх, хянах боломжтой модулийг хөгжүүлсэн байх (жишээ нь: программ хангамжид хийсэн хандалт, үйлдэл, цаг хугацааг бүртгэх)	+	
		6.	Нууц үгийг эргэж тайлагдахгүй байдлаар (one-way encryption) хадгалдаг байх	+	
		7.	Мэдээллийг халхлах (mask) тохиргоо хийх боломжтой байх	+	
1.2.	Хэрэглэгч	8.	Хэрэглэгчийн хандах эрхийн удирдлагатай байх (хэрэглэгч тус бүрээр үйлдлийг тохируулдаг байх гэх мэт)	+	
		9.	Хэрэглэгчийн нэвтрэх нэр эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн кодтой уялдсан байх	+	
		10.	Хэрэглэгчийн үйлдлийн тохиргоо нь эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй уялдсан байх	+	
		11.	Нууцад хамаарах мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах эрхийг тусгайлан тохируулдаг байх (Жишээ нь: "ДОХ"-ын шинжилгээний хариу гэх мэт)	+	
		12.	Хэрэглэгчийн нэвтрэх оролдлогын тоог хязгаарладаг байх	+	
		13.	Хэрэглэгчийн үйлдэл тодорхой хугацаагаар идэвхгүй болоход холболт автоматаар салдаг байх (Session)	+	
		14.	Хэрэглэгч нууц үгээ мартсан тохиолдолд админы дэмжлэггүйгээр сэргээх боломжтой байх	+	

1.3.	Мэдээллийн эзэн	15.	Үйлчлүүлэгчийг Монгол Улсын иргэний бүртгэлийн дугаараар, шаардлагатай бол регистрийн дугаараар таньж, тодорхойлдог байх	+	
		16.	Үйлчлүүлэгчийг гадаадын иргэний бүртгэлийн дугаар (F register), шаардлагатай бол паспортын дугаар (гадаадын иргэн, харьяалалгүй хүн)-аар таньж, тодорхойлдог байх	+	
		17.	Үйлчлүүлэгчийн бүртгэл үүсгэх, шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны үндсэн системээс татдаг байх	+	
		18.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс бусад зорилгоор хүний хувийн мэдээлэлд хандах (цуглуулах, боловсруулах, ашиглах)-даа мэдээллийн эзнээс өөрөөс нь, зөвшөөрөл өгөх чадамжгүй тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах боломжийг бүрдүүлсэн байх.	+	
19.	Үйлчлүүлэгчийн мэдээлэлд хандсан үед "Мэдэгдэл" хүргэдэг байх	+			
1.4.	Программ хангамжийн ажиллагаа ба UI/UX	20.	Эрх бүхий байгууллагаас тогтоосон цагийн улсын эталоныг ашигласан байх	+	
		21.	Программ хангамжийн интерфэйс монгол хэл дээр байх		+
		22.	Цахим хэлбэрээр гарын үсгийг зурах боломжтой байх	+	
		23.	Системд байгаа мэдээллийг давхардуулж бүртгэхгүй, автоматаар татаж харуулдаг байх	+	
		24.	Хайлтыг шаардлагатай гэж тодорхойлсон бүх төрлийн талбарын утгаар хийдэг байх (Жишээ нь: үйлчлүүлэгчээр, өвчнөөр, оношоор, эмчээр, өгөгдсөн хугацааны хооронд болон бусад)	+	
		25.	Заавал бөглөх талбарыг ялгаж харуулдаг, бөглөөгүй үед сануулга өгдөг байх	+	
		26.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг дагаж өөрчлөх боломжтой байх	+	
		27.	Мэдээллийг өгөгдсөн хугацаагаар нөөцөлдөг байх (Backup)	+	
		28.	Шаардлагатай мэдээллийг бүртгэсэн үеийн байдлаар хадгалдаг байх	+	
		29.	Мэдээллийг хадгалахдаа огноо, цагийг серверийн цагаар хадгалах	+	
		30.	Программ хангамжийн тохиргооны болон суурилуулалтын гарын авлагатай байх	+	
		31.	Программ хангамжийн хэрэглэгчийн гарын авлагатай байх	+	
32.	Үйлчилгээний нөхцөл, шаардлагатай байх		+		
1.5.	Мэдээлэл солилцоо	33.	Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР) системтэй холбогдсон байх (мэдээлэл нийлүүлэх, хүлээн авах)	+	
		34.	Эрүүл мэндийн салбарын мэдээлэл	+	

		солилцооны системтэй зохих стандартын дагуу холбогддог байх (мэдээлэл нийлүүлэх, хүлээн авах)		
		35. Нийтийн сүлжээ (internet)-ээр мэдээлэл солилцохдоо мэдээллийг шифрлэсэн (encrypt) байх, SSL холболттой байх	+	
		36. Мэдээллийг амжилттай дамжуулсан эсэхийг бүртгэж, мэдээлдэг байх	+	
		37. Сервис (API)-ийн оролт, гаралтыг тодорхойлсон гарын авлагатай байх	+	
		38. Мэдээлэл дамжуулалтын тасалдал, саатлыг бүртгэж, системийн зохицуулагч (administrator) руу мэдээлдэг байх	+	
1.6.	Тайлан	39. Батлагдсан маягтын дагуу тайлан, мэдээг гаргадаг байх	+	
		40. Тайлан, мэдээллийг XLS, CSV гм олон төрлийн файлын форматаар татан авах боломжтой байх	+	
		41. Тайлан, мэдээллийг хэвлэх боломжтой байх		+

Хоёр. ТУСГАЙ ШААРДЛАГА

Энэхүү тусгай шаардлага дахь "Зайлшгүй шаардлагатай" байх шалгуур үзүүлэлт нь уг жагсаалтын гуравдугаар хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллагын төрөл, түүний үйл ажиллагааны чиглэлээс хамаарах ба "Зөвлөмжийн шинжтэй" байх шалгуур үзүүлэлтийг заавал хөгжүүлж, нэвтрүүлэхгүй байж болно.

2.1.	Мэдээллийн ангилал, код, тайлбар, кодчиллол	42. Цахим хөгжил, харилцаа холбооны болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан эрүүл мэндийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, тайлбарыг ашигласан байх	+	
		43. Олон улсын ICD кодчиллыг ашигласан байх	+	
		44. Олон улсын SNOMED CT стандарт, кодчиллыг ашигласан байх		+
		45. Олон улсын LOINC стандарт, кодчиллыг ашигласан байх		+
		46. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн мэдээллийн сангаас татаж ашигладаг байх	+	
		47. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн кодчиллыг эрүүл мэндийн даатгалын мэдээллийн сангаас татаж ашигладаг байх	+	
		48. Өвчний түүх болон тусламж, үйлчилгээний бүртгэлийн дугаарыг давхардуулахгүй үүсгэдэг байх	+	
		49. Өвчний түүх болон тусламж, үйлчилгээний бүртгэлийн дугаарыг тогтоосон хугацаанаас эхлэн мэдээллийг шинээр тоолох боломжтой байх (YYYYMMDDXXXXXXXX)	+	
2.2.	ЭМС-ын баталсан анхан	50. Тухайн эрүүл мэндийн байгууллагад хамаарах маягт дахь мэдээллийг бүрэн бүртгэдэг байх	+	

	шатны бүртгэлийн болон тайлангийн маягтад нийцсэн байх	51.	Маягтын загварын дагуу pdf файл үүсгэн илгээдэг байх	+		
		52.	Маягт бүрийн мэдээллийг харилцан уялдаа холбоотой боловсруулдаг байх	+		
		53.	Маягтыг загварыг шинээр үүсгэх, өөрчлөх тохиргоог хэрэглэгч өөрөө хялбар хийдэг байх (динамик тохируулга)			+
		54.	Маягтын загвар дахь тохирох хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллагын нэр, лого гэх мэт мэдээллийг чөлөөтэй оруулах боломжтой байх			+
2.3.	Оношилгоо, шинжилгээ	55.	Дүрс оношилгооны тоног төхөөрөмжтэй холбогдох боломжтой байх (DICOM)			+
		56.	Дүрс оношилгооны мэдээллийг автоматаар хадгалах боломжтой байх (PACS)			+
		57.	Дүрс оношилгооны төрөл бүрд тохирсон дүгнэлт бичих батлагдсан маягтыг нэвтрүүлсэн байх (цээжний рентген, гар сарвууны рентген, хэвлийн ЭХО, бамбайн ЭХО, СТ, MRI гэх мэт)	+		
		58.	Лабораторийн тоног, төхөөрөмжтэй холбогдон ажиллаж, хариуг автоматаар татдаг байх			+
		59.	Тухайн лабораторийн тоног, төхөөрөмжийн лавлах хэмжээтэй харгалзуулан шинжилгээний хариуг татаж авдаг байх	+		
		60.	Шинжилгээний төрөл бүрд тохирсон хариу бичих батлагдсан маягтыг нэвтрүүлсэн байх (Биохимийн шинжилгээ, шээсний шинжилгээ гэх мэт)	+		
		61.	Дүрс оношилгооны зураг, бичлэг болон бусад мэдээллийг зориулалтын программ хангамж (radiant гэх мэт)-ийг ашиглан харах боломжтойгоор дамжуулдаг байх (url)			+
		62.	Дүрс оношилгооны дүгнэлт, шинжилгээний хариуны мэдээлэл солилцох	*.pdf файл үүсгэн хадгалж, илгээдэг байх	+	
		63.		Илгээсэн линк (url) солигдохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх	+	
		64.		Линк (url) нь шууд уншигдахааргүй нууцалсан, баталгаажуулалт шаарддаг байх	+	
65.	Бодит цаг хугацаанд эмч, ажилтан болон үйлчлүүлэгчид	+				

			илгээдэг байх	
2.4.	Эмчилгээ	66.	Өвчний түүхийг иж бүрэн хөтлөх, харах, хайх боломжтой байх	+
		67.	Сувилгааны түүхийг иж бүрэн хөтлөх хөтлөх, харах, хайх байх	+
		68.	Эмчийн үзлэгийн түүхийг хөтлөх хөтлөх, харах, хайх байх	+
		69.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл бүрээр мэдээллийг иж бүрэн бүртгэх, харах, хайх боломжтой байх	+
		70.	Төрөлт, нас баралтын мэдээллийг бүртгэх, хайх, харах, мэдээлэх боломжтой байх	+
		71.	Тасаг, кабинет, өрөө хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлдэг байх	+
2.5.	Цахим бүртгэл	72.	Тусламж, үйлчилгээний хуваарийг удирдах боломжтой байх (эмчийн үзлэгийн цаг товлох, өөрчлөх, цуцлах гэх мэт)	+
		73.	Тусламж, үйлчилгээний сул цагийг харуулах боломжтой байх	+
		74.	Эрүүл мэндийн даатгалтай эсэхийг шалгадаг байх	+
		75.	Тусламж, үйлчилгээ үзүүлсэн баримтыг олгодог байх	+
		76.	Тухайн үйлчлүүлэгчийн захиалгын давхардлыг шалгахад байх	+
		77.	Тухайн үйлчлүүлэгчийн өмнө авсан үйлчилгээний мэдээллийг хардаг байх	+
		78.	Эрүүл мэндийн лавлагаа, тодорхойлолт болон шаардлагатай зөвшөөрлийн маягыг бүртгэх, харах, хайх боломжтой байх	+
		79.	Тусламж, үйлчилгээний хөнгөлөлт оруулах боломжтой байх	+
		80.	Цахим бүртгэлийн мэдээг төрөл бүрээр боловсруулдаг байх	+
		81.	Эмнэлгийн кассын ажиллагаатай холбогдон ажилладаг байх	+
2.6.	Яаралтай тусламж	82.	Яаралтай тусламжийн үзлэгийн хуваарийг удирдах боломжтой байх (бүртгэх, өөрчлөх, цуцлах гэх мэт)	+
		83.	Яаралтай тусламж үзүүлсэн тухай мэдээллийг бүртгэх, хайх, харах, мэдээлэх боломжтой байх	+
		84.	Яаралтай тусламжийн эрэмбэлэн ялгалтыг тэмдэглэх боломжтой байх	+
		85.	Яаралтай тусламж үзүүлэхэд заавал үйлчлүүлэгчийн зөвшөөрөл шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх (нөхөж бүртгэх боломжтой байх)	+
2.7.	Нийгмийн эрүүл мэнд	86.	Үйлчлүүлэгч рүү эрүүл мэндийн зөвлөгөө, сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэдэг байх	+

		87. Шаардлагатай асуумж, судалгаа авах боломжтой байх		+
		88. Эрүүл мэндийн хичээл үзэх боломжтой байх		+
		89. Эрүүл мэндийг үнэлэх боломжтой байх		+
2.8.	Тохиргоо (system administrator)	90. Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр ажиллах цагийг тохируулан, удирдах боломжтой байх (жишээ нь: Мэдрэлийн кабинет 2024.. ... өдөр 10.00-14.00 цагийн хооронд цаг олгох боломжтой байх тохиргоог хийх)	+	
		91. Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр нормыг тохируулан, удирдах боломжтой байх	+	
		92. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл бүрээр төлбөрийн мэдээллийг тохируулан удирдах боломжтой байх (эрүүл мэндийн даатгалын төлбөр, төлбөрт үйлчилгээ гэх мэт)	+	
		93. Статистик, мэдээллийн тохиргоог удирдах боломжтой байх	+	
		94. Лабораторийн тохиргоог удирдах боломжтой боломжтой байх (тоног төхөөрөмж, лавлах хэмжээ, ашиглалт, тайлан мэдээ гэх мэт)	+	
		95. Дүрс оношилгооны тохиргоог удирдах боломжтой боломжтой байх (тоног төхөөрөмж, ашиглалт, тайлан мэдээ гэх мэт)	+	
		96. Эмч, ажилтны үйлдлийн тохиргоог удирдах боломжтой байх	+	
		97. Жижүүр эмч, сувилагчийн цагийн хуваарийг тохируулдаг байх	+	
		98. Эмнэлгийн нөөцийн мэдээллийн тохиргоог удирддаг байх	+	
		99. Эмнэлгийн орны мэдээллийн тохиргоог удирддаг байх	+	
100. Эмнэлгийн өрөө, тасаг, кабинетыг тохиргоог удирддаг байх	+			
2.9.	Эмийн жор	101. Үйлдвэрлэлийн цувралын дугаарыг харуулдаг байх	+	
		102. Барааны баркодоор бүртгэж, хайдаг байх	+	
		103. Тухай оношд хамаарах эмийн мэдээллийг лавлан, дууддаг байх		+
		104. Эмийг олон улсын нэршлээр хайдаг байх	+	
		105. Холимог найрлагатай болон уламжлалтын эмийг худалдааны нэршлээр хайдаг байх	+	
		106. ОУ-ын нэршил болон худалдааны нэршлийн аль нэгнээр хайхыг заасан хялбар тэмдэглэгээтэй байх		+
		107. Эмийн жорын түүхийг жорын дугаараар	+	

		лавлаж, харах боломжтой байх		
108.		Эмийн жорын түүхийг үйлчлүүлэгчийн регистрийн дугаараар лавлаж, харах боломжтой байх	+	
109.		Тодорхой эм ууж буй үйлчлүүлэгчдийг хайх боломжтой байх	+	
110.		Үйлчлүүлэгч дурын жилээр жорын түүхийг харах боломжтой байх	+	
111.		Эмийн жор бичилтийг MNS 5376:2016 стандартын дагуу бүртгэх, хэвлэх, илгээдэг байх байх	+	
112.		Эмийн гаж нөлөөг бүртгэж, илгээдэг байх	+	
113.		Сэтгэцэд нөлөөт болон мансууруулах эмийн жорын зөвшөөрлийг олгодог байх.	+	
114.		Худалдаж авсан эмийг И-Баримтын хялбар бүртгэл хийдэг байх		+
115.		Эмчид бичсэн жорыг мөрдсөн эсэхийг харуулдаг байх (худалдан авсан болон бичсэн жорын мэдээлэл нэг дор харагддаг байх)		+
116.		Эмийн харилцан үйлчлэл, эмийн харшлыг шалгах, сэрэмжлүүлэх боломжтой байх		+

Гурав. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛД ХАМААРАХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН МОДУЛИЙН БҮРДЭЛ

Энэхүү хэсэгт "Зайлшгүй шаардлагатай" байх шалгуур үзүүлэлтийг "+" тэмдгээр тэмдэглэв. Тухайн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч нэмэлт модуль, функцийг хөгжүүлэн, нэвтрүүлж, ашиглахыг хориглоогүй болно.

№	МОДУЛИЙН НЭР	Өрхийн эмнэлэг	Сум, тосгоны эмнэлэг	Нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, амаржих газар, тусгай эмнэлэг, клиник эмнэлэг	Сувилахуйн төв, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, сэргээн засах төв	Тусгай мэргэжлийн төв	Түргэн тусламжийн төв	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг хялбарчлалтын үндэс хангах байгууллага	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага (лаборатори)	Нийгмийн эрүүл мэндийн төв
3.1.	Цахим бүртгэл	+	+	+	+	+	+	+	+	+
3.2.	Удирдлагын хяналт, мэдээлэл	+	+	+	+	+	+	+	+	+
3.3.	Амбулатори	+	+	+	+	+	+	+	+	+
3.4.	Хэвтэн эмчлүүлэгчийн бүртгэл (стационари)	+	+	+	+	+	+	+	+	+
3.5.	Яаралтай тусламж	+	+	+	+	+	+	+	+	+
3.6.	Сувилахуй	+	+	+	+	+	+	+	+	+
3.7.	Лаборатори	+	+	+	+	+	+	+	+	+
3.8.	Дүрс оношилгоо	+	+	+	+	+	+	+	+	+
3.9.	Эм, эмнэлгийн хэрэгсэл	+	+	+	+	+	+	+	+	+
3.10.	Статистик, тайлан, мэдээ	+	+	+	+	+	+	+	+	+
3.11.	Эрүүл мэндийн даатгал	+	+	+	+	+	+	+	+	+
3.12.	Санхүү	+	+	+	+	+	+	+	+	+
3.13.	Тохиргоо (backend)	+	+	+	+	+	+	+	+	+
3.14.	Эрүүл мэндийн цахим карт (үйлчлүүлэгчийн үйлчилгээ авсан түүх дэлгэрэнгүй)	+	+	+	+	+	+	+	+	+
3.15.	Эмнэлэгт үйлчлүүлэгч илгээх, хүлээн авах	+	+	+	+	+	+	+	+	+

Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа
холбооны сайдын хамтарсан 2024 оны 03 сарын 26
өдрийн 4136/А.27 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД
ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ
МЭДЭЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж /цаашид “программ хангамж” гэх/-д үнэлгээ хийж, шаардлагад нийцсэн программ хангамжийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

**Хоёр. Үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
түүний зохион байгуулалт**

2.1. Эрүүл мэндийн сайд болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан байнгын ажиллагаатай ажлын хэсэг программ хангамжид үнэлгээ хийж, дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Ажлын хэсэг дараах байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

2.2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-1;

2.2.2. Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл-1;

2.2.3. Тагнуулын ерөнхий газрын Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв-1;

2.2.4. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-1;

2.2.5. Эрүүл мэндийн хөгжлийн төв-1;

2.2.6. И-Монгол академи УТҮГ-ын төлөөлөл -1;

2.2.7. Үндэсний Дата Төв УТҮГ-ын төлөөлөл-1;

2.2.8. Эрүүл мэндийн салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл-1;

2.2.9. Мэдээллийн технологийн салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл-1

2.3. Энэ журмын 2.2.8, 2.2.9-д заасан гишүүнийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэж томилно.

2.4. Ажлын хэсгийн үйл ажиллагаа хуралдаан хэлбэртэй байна. Ажлын хэсгийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл даргална.

2.5. Ажлын хэсгийн хурал 7 болон түүнээс дээш гишүүдийн ирцтэйгээр хүчин төгөлдөрт тооцогдох ба шийдвэр нь хурлын тэмдэглэлд үндэслэсэн дүгнэлт, зөвлөмж байна.

2.6. Ажлын хэсгийн нарийн бичгийг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс томилох бөгөөд нарийн бичиг нь хурлын тэмдэглэлийг хөтөлж, хуралд саналын эрхгүй оролцоно.

2.7. Хуралдаачны дэгийг хууль, журамд заасан нийтлэг зохицуулалтын дагуу боловсруулж, хуралдаанаараа хэлэлцэн батална.

2.8. Ажлын хэсгийн хуралд тухайн хүсэлт гаргасан программ хангамж хөгжүүлэгчийн төлөөлөл оролцоно.

2.9. Ажлын хэсгийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд биечлэн оролцох боломжгүй бол тухайн гишүүнийг хуралд цахим хэлбэрээр оролцуулж болно.

2.10. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.11. Энэ журмын 2.11-т заасан шийдвэр нь дүгнэлт хэлбэртэй байх бөгөөд ажлын хэсгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12. Ажлын хэсгийн хуралд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн болон холбогдох бусад салбарын мэргэжлийн зөвлөл, мэргэжлийн холбоодын төлөөлөл, шинжээчийг саналын эрхгүйгээр оролцуулж болно.

2.13. Ажлын хэсгийн гишүүн программ хангамжаа үнэлүүлэх хүсэлт ирүүлсэн байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой, хамаарал бүхий этгээд байх тохиолдолд хурлын даргад мэдэгдэж, тухайн хуралд оролцох эсэх талаар зөвшөөрөл авна.

2.14. Программ хангамжийн үнэлгээтэй холбоотой санал, гомдлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд гаргана.

Гурав. Программ хангамжид үнэлгээ хийх, мэдээлэх

3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамж хөгжүүлэгч нь хөгжүүлсэн программ хангамжаа үнэлүүлэх тухай хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаасаар, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ:

3.1.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.1.2. байгууллагын танилцуулга, туршлага, хүний нөөцийн мэдээлэл;

3.1.3. программ хангамжийн модулийн жагсаалт, ашиглаж буй технологийн танилцуулга;

3.1.4. үйлдлийн систем, тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга;

3.1.5. мэдээллийн сүлжээ болон программ хангамжийн бүтэц схем;

3.1.6. программ хангамжид ашиглагдаж буй гуравдагч талын сервис ашиглах бол тэдгээрийн жагсаалт;

3.1.7. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас тухайн программ хангамжид хийсэн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;

3.1.8. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан шаардлагыг хангаж байгаа талаарх нотлох баримтыг тайлбарын хамт ирүүлэх;

3.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн бүрдүүлбэрийн шаардлага хангасан эсэхийг ажлын 3 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан бол ажлын хэсэгт болон хүсэлт гаргагч этгээдэд, шаардлага хангаагүй бол хүсэлт гаргагч этгээдэд бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

3.3. Ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан энэ тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан холбогдох шаардлагын дагуу программ хангамжид үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

3.4. Ажлын хэсгийн шийдвэрээр шаардлага хангасан программ хангамжийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төв бусад системээс ялгагдах тэмдэглэгээтэйгээр Үндэсний программ хангамжийн их дэлгүүр "Mindgolia.mn" дэмжих системд болон өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.

3.5. Ажлын хэсэг шаардлага хангаагүй тухай шийдвэрийг энэ журмын 3.1-д заасан хүсэлт гаргагчид ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

3.6. Ажлын хэсэг программ хангамж, шаардлага өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлтөд хамааралтай хэсэгт хэсэгчлэн дүгнэлт гаргаж болно.

3.7. Дүгнэлт гарсан программ хангамжид өөрчлөлт, шинэчлэлт орсон, шинэ модуль, функц нэмэгдсэн тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдэгдэж, дахин дүгнэлт гаргуулах эсэхийг ажлын хэсгээр шийдвэрлүүлнэ.

3.8. Тус журмын хавсралтаар заасан шаардлага шинэчлэгдсэн бол өмнө дүгнэсэн программ хангамжуудыг Эрүүл мэндийн хөгжлийн төв нягтлан үзэж, холбогдох өөрчлөлтөд тохирох хэсэгт дахин дүгнэлт гаргуулах эсэхийг тогтооно.

3.9. Тус журмын хавсралтаар заасан эрүүл мэндийн программ хангамжид тавигдах шаардлага, эрүүл мэндийн байгууллагын төрөл, модуль зэргийг хууль тогтоомж, технологийн хөгжилд нийцүүлэн тухай бүр Эрүүл мэндийн хөгжлийн төв өөрчлөх саналыг боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.